

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2018 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД
ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2018.06.14


Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2018 оныг “**Цахим үйлчилгээг хөгжүүлэх жил**” Дүүргийн Засаг даргын Тамгын газраас “**Өрхийн хөгжлийг дэмжих жил**” болгон зарласантай холбогдуулан “Нийгмийн даатгалын тухай” хуулийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг найдвартай, хөнгөн шуурхай хүргэх, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох, нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандарт, чанар, хүртээмж, үйлчилгээний соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажлаа төлөвлөн ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Бүтэц, орон тоо батлах тухай А/22 дугаар тушаалын дагуу Орлого, шимтгэлийн тасаг, Санхүү бүртгэлийн тасаг, Хяналт, шалгалт дотоод аудитын тасаг, Үйлчилгээний тасаг, Хайлааст дахь нийгмийн даатгалын тасаг гэсэн 5 алба, 61 орон тоотойгоор Нийгмийн даатгалын тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдаа хүргэх, мэдээ, мэдээллийг стандартын дагуу гарган тайлагнах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэлээ.

Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн талаар:

Тус хэлтэс 2018 оны 2-р улиралд иргэд, даатгуулагчдад эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, соёлч шуурхай хүргэж, даатгуулагчдын хамрах хүрээг өргөтгөж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгож, давхардсан тоогоор 179920 иргэнд эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэв.

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 108997.34 сая төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 113359.2 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөт зорилтоо 104.0 %-иар биелүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн орлого 19052.14 сая төгрөгөөр буюу 20.2 %-иар өслөө.



Төвлөрсөн харилцахад ажил олгогчийн төлсөн шимтгэл, сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэл, акт алдангийн орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын эзлэх хувиар хуваарилж тэтгэврийн санд 74136.92 сая төгрөг, тэтгэмжийн санд 8501.94 сая төгрөг, ҮОМШӨ даатгалын санд 9805.57 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 1927.11 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 18987.66 нийт 113359.2 сая төгрөгийг хуваарилав.

Нийгмийн даатгалын сангийн зарлагын төвлөрүүлэлтийг тэтгэврийн санд 23161.9 сая төгрөг, тэтгэмжийн санд 2135.56 сая төгрөг, ЭМД санд 15866.31 сая төгрөг, ҮОМШӨ даатгалын санд 7537.83 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд 635.0 сая төгрөг нийт 49336.6 сая төгрөгийг төвлөрүүлэв.

Тэтгэвэр тэтгэмж олголтын талаар:


Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангуудаас 43991.22 сая төгрөгийн тэтгэвэр, 6775.63 сая төгрөгийн тэтгэмж олгож Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж төлбөрийг олгохдоо анхан шатны холбогдох баримтуудыг шалган хуулийн дагуу цаг хугацаанд нь бүрэн олгож ажиллалаа.

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 15434 өндөр насны тэтгэвэр авагчдад 33850.03 сая төгрөг, 3008 тахир дутуугийн тэтгэвэр авагчдад 4493.08 сая төгрөг, 927 тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдад 1467.38 сая төгрөг, 1279 цэргийн тэтгэвэр авагчдад 4180.73 сая төгрөг, 185 ҮОМШӨДС-аас тэтгэвэр авагчид 469,25 сая төгрөг нийт 20833 тэтгэвэр авагчдад 44460,47 сая төгрөгийн тэтгэврийг цаг хугацаанд нь олголоо.



Тэтгэвэр авагчдад олгосон тэтгэвэр / сая.төг/



Бүх төрлийн тэтгэврийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн, сунгалтын өөрчлөлтийг тухай бүр хийж мэдээллийн санд орууллаа.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа цуцлагдсан, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч хөдөлмөрийн чадваргүй гишүүн 19 насанд хүрсэн, тэтгэвэр авагч нас барсан зэрэг шалтгаанаар 221 иргэний, өндөр насны нас барсан шалтгаанаар 219 тэтгэвэр олголтыг зогсоож хувийн хэргийг бүртгэлийн хамт архивт шилжүүллээ.

Тайлангийн хугацаанд бусад аймаг, дүүргээс 78 тэтгэвэр авагч шилжин ирж, 162 тэтгэвэр авагч шилжин явсан байна.

Тэтгэврээс шүүхийн суутгал төлдөг 32 хүний суутгал болох 20,1 сая төгрөгийн тэтгэврийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албанд шилжүүллээ.


2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулинд орсон өөрчлөлтийн дагуу тэтгэвэр тогтоосон цалингаа өөр оны цалингаар тооцуулж тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргасан 7 иргэний тэтгэврийг өөрчлөн тогтоолоо.

Ажилласан жил нэмүүлэх болон цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 2 дахь заалтын үндэслэлээр тэтгэврийн өөрчлөлт хийлгэх хүсэлтэй 564 тэтгэвэр авагчидын тэтгэврийн өөрчлөлт хийв.


Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 19 –ны өдрийн 16 дугаар тогтоолын дагуу 20518 тэтгэвэр авагчдын нэмэгдэл хийж хувийн хэрэгт бичилт хийв.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны 6985 даатгуулагчдад 945.85 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 3049 даатгуулагчдад 4712.47 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 29 хүний 29.0 сая төгрөг, ҮОМШӨвчний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны 60 даатгуулагчдад 34.49 сая төгрөг, ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгуулагчийн шимтгэлд 27.41 сая төгрөгийг олголоо. Ажилгүйдлийн даатгалын сангаас 655 даатгуулагчдад 1026.41 сая төгрөгийг олголоо.

Тэтгэмж авагчдын тооны өсөлт



Тэтгэмжид зарцуулсан зардал /сая.төгрөг/



Сайн дурын даатгалын хамралт, орлого бүрдүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 2018 онд давхардсан тоогоор 10174 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажиллаж, нийгмийн даатгалын санд 2892.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2780.8 сая төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 96.1 хувиар биелүүлэв.

Тус хэлтэстэй 2018 онд “Сайн дураар даатгуулах тухай гэрээ” байгуулсан боловч хуулийн хугацаанд шимтгэлээ төлөөгүй хугацаа хожимдуулан төлсөн 1252 даатгуулагчид нийт 5.4 сая төгрөгийн алданги ногдуулж, алдангийг нийгмийн даатгалын санд төлүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн хороод болон тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Бөмбөгөр”, “Алтжин бөмбөгөр”, “Юмт бөмбөгөр”, “Хүчит шонхор”, “Хүчит шонхор-2”, “Нарантуул-2”, “Теди”, “Victoria”, “Цэцэг” худалдааны төвүүдэд нийгмийн даатгалд хамрагдаагүй хувь хүмүүсийг нийгмийн даатгалын сайн дурын даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг давхардсан тоогоор 12 удаа зохион байгуулан ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын орлого бүрдүүлэлтийн ажлын талаар:

. Тус дүүргийн иргэд, даатгуулагчид, мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулийн оюутан суралцагчдыг “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаа.

2018 оны эхний хагас жилд тус дүүргийн ажил хөдөлмөр эрхлээгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 9621 иргэн, мэргэжлийн сургуульд суралцагч 1390 иргэн, гадаадын иргэн харьяалалтай хүн 9 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, нийгмийн даатгалын санд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого 419.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 480.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 114.4 хувиар биелүүллээ.

Эрүүл мэндийн даатгалыг төрөөс хариуцах иргэд болох 0-19 насны 363 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 97 иргэн, хүүхдээ асрах чөлөөтэй 283 эх, нийгмийн халамжийн тэтгэвэр авагч 31 иргэн нийт 780 иргэний гэрүүл мэндийн даатгалд хамрууллаа.

2018 оны 02 дугаар сард Чингэлтэйдүүргийн 12, 13, 14, 15 дугаар хорооны иргэд, даатгуулагчдад “Эрүүл мэндийн даатгалын тухай” хууль, тогтоомжийг сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2018 оны “2018 оны нэгдүгээр ээлжийн цэрэг халах, татах ажлыг зохион байгуулах тухай” А/207 дугаар захирамжийн дагуу цэрэг татлагын ажилд оролцож, шинээр цэрэгт татагдан явж буй 18-25 насны 176 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулав.

Амьжиргааны түвшингээс доогуур орлоготой Засгийн газрын нийгмийн хамгааллын арга хэмжээний дагуу нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 1350 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл 77,7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж бүрдүүллээ.

Нийгмийн даатгалын сангийн авлагыг бууруулах талаар дараах арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулахад оны эхнээс анхаарч ажиллаж, тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 74 уулзалт хийж, 168 байгууллагад нийгмийн даатгалын улсын байцаагчийн албан шаардлага өгч, 93 байгууллагын банкин дахь харилцах дансны гүйлгээг зогсоож, 21 байгууллагатай өр авлага барагдуулах график байгуулан ажилласны үр дүнд оны эхний 1702 ажил олгогчийн 13658.0 сая төгрөгийн авлагаас 973 байгууллагын 4861.4 сая төгрөгийн авлагыг барагдууллаа.

Оны эхэнд 24 байгууллагын 1531.6 сая төгрөгийн шүүхийн шийдвэртэй нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай гарсан бөгөөд тайлант онд нэмж 8 байгууллагын 200.9 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гарснаар 32 байгууллагын 1732.5 сая төгрөгийн шүүхийн шийдвэртэй авлагатай болсон. Үүнээс 4 байгууллагын 29.6 сая төгрөгийн авлага барагдаж 28 байгууллагын 1702.9 сая төгрөгийн шүүхийн шийдвэртэй авлагын үлдэгдэлтэй байна. Энэхүү 28 байгууллагын 21 байгууллагад шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудсыг гаргуулан авч

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд өгснөөр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

2018 оны эхний хагас жилд нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 22 байгууллагыг шүүхэд өгснөөс хаяг тодорхойгүй үндэслэлээр шүүхээс буцсан 12 байгууллагыг эрэн сурвалжлуулахаар хүсэлт гаргалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Аян зарлах тухай” А/62 тоот тушаалаар нийгмийн даатгалын шимтгэлийн хамгийн их өртэй 50 байгууллагын өрийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 60 хоногийн хугацаанд нийт өрийн 50-иас доошгүй хувиар барагдуулах үүрэг өгөгдсөний дагуу өр авлага барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд эхний мэдээгээр хамгийн их өртэй 50 байгууллагын 6637.3 сая төгрөгийн өрөөс 19 байгууллагын 855.0 сая төгрөгийн өрийг барагдуулсан байна.

Нэрийн данс, төсөв, төсөөлөл боловсруулах, төлөвлөлтийн талаар:

Даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл авах “Даатгуулагчийн бүртгэл” ndaatgal.mn цахим бүртгэлд бүртгэснээр даатгуулагч өөрийн авсан цалин хөлс, төлсөн шимтгэл, зардлыг цахим хаягаараа хүлээн авах боломжтой болж байгаа бөгөөд энэ мэдээллийг ажил олгогч даатгуулагчдад өгч ажиллаж байна. Нэрийн дансны 2016 оны үлдэгдлээрхи мэдээлэх хуудсыг 2 ажил олгогчийн 2 албан журмын даатгуулагчид хүсэлтийн дагуу нэрийн дансны мэдээллийг өгсөн.

БНСУ-д ажиллаж Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас шимтгэл буцаан авах эрх үүссэн 1 даатгуулагчид 1079.1 мянган воны буцаан олголтын бичиг баримтыг шалган хүлээн авч бүртгэлийн хураамжаар 45.0 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлэн тайлагнасан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Хэлтсийн даргын 2015 оны А/02 тоот тушаалаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх болон хяналт тавих ажилтнуудын ажил үүргийн хуваарийг баталж, биелэлтийг ханган ажиллаж байна.

Сар бүрийн мэдээ, улирал, жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, орлого зарлагын гүйлгээ зэргийг www.shilendans.gov.mnсайтад байршуулан нээлттэй ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Шилэн дансны www.shilendans.gov.mnсайтад:

- ✓ Жилийн төсөв, төлөвлөгөө /файлаар/ -1ш
- ✓ Байгууллагын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ- 6ш
- ✓ Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээ /файлаар/ -6ш
- ✓ Жилийн эцсийн нэгтгэсэн тайлан /файлаар/-1ш
- ✓ Улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэтрэлт, хэмнэлтийн тайлбар /файлаар/-2ш
- ✓ Тэтгэвэр тэтгэмж авагчдын тоо, хөрөнгийн хэмжээ -6ш
- ✓ 5.0 сая төгрөгөөс дээш хийгдсэн орлого зарлагын мөнгөн гүйлгээ -6ш
- ✓ 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт -12ш
- ✓ Байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн жагсаалт-6ш-ийг тус тус байршуулсан байна.

Хэлтсийн байрны 1 давхарт “Шилэн дансны нээлттэй мэдээлэл” самбарын мэдээллийг тухай бүр шинэчлэн хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна.

Үйл ажиллагааны зардлын талаар

Байгууллагын урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан “Үйл ажиллагааны зардлын 2018 оны төсвийн сарын хуваарь”-ийн дагуу бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулан, Төсвийн тухай хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын урсгал зардал тухайн улиралд 358.75 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөгөө батлагдснаас 352.01 сая төгрөгийг зарцуулан, дээд газрын шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан.

Өмч хамгаалах байнгын комисс нь өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд өдөр тутам хяналт тавьж, бүртгэл хөтлөн ажиллажжилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг явуулахад хөрөнгийн зөрчил гараагүй болно

Хяналт шалгалтын чиглэлээр:

Дүүргийн нутаг дэвсгэрт “Нийгмийн даатгалын тухай” хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавих, тус хэлтэстэй харилцагч ажил олгогч байгууллагуудад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллав.

Ажил олгогч байгууллага шалгасан ажлын талаар:

2018 оны 2 дугаар улиралд 245 ажил олгогчийг хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу “Нийгмийн даатгалын тухай” хууль, тогтоомжийн хэрэгжилт, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцсон нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийг тухайн байгууллагын тушаал шийдвэр, хөдөлмөрийн гэрээ, санхүүгийн бусад баримтад тулгуурлан шалгав.

Шалгалтаар 76 ажил олгогчийн 208 даатгуулагчийн 759,2 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох 150,4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлгүй орхигдуулсныг нөхөн төлүүлж, 75,2 сая төгрөгийн алданги тооцож, нийт 226,1 сая төгрөгийн актын төлбөрийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж, зөрчлийг арилгав.

Үүнээс ажил олгогч, иргэд даатгуулагчаас ирсэн өргөдөл хүсэлтийн дагуу 42 ажил олгогчийн 35 даатгуулагчийн 113,1 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох 17,9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлгүй орхигдуулсныг нөхөн ногдуулж, 8,9 сая төгрөгийн алданги тооцож, нийт 26,8 сая төгрөгийн актын төлбөрийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж, өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэв. Шалгалтын явцад 10 байгууллагын 110,3 сая төгрөгийг төлүүлээ.

Шалгалтаар илэрч буй зөрчлүүд:

- Хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлгүй орхигдуулсан
- Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлгүй орхигдуулсан
- Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг бууруулах болон нуун дарагдуулж тайлагнасан /үндсэн цалин, шагнал урамшуулал, хоол, унааны хөнгөлөлт/

Дотоодын хяналт шалгалтын ажлын талаар:

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны,

ажилгүйдлийн тэтгэмж тогтоосон материалыг цаг тухайд нь шалгаж, илэрсэн зөрчлийг тухай бүр залруулан ажиллалаа.

Тус хэлтэс 2018 оны 2-р улирлын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас 6041 даатгуулагчид 805,1 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 2659 даатгуулагчид 4174,1 сая төгрөгийн жирэмсэн болон амаржсаны тэтгэмж, 26 даатгуулагчид 26,0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 42 даатгуулагчид 27,1 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 578 даатгуулагчид 888 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус шалгалаа.

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын ажлын талаар:

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/39.А/12 тоот хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан “Даатгуулагч/иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа” жагсаалтыг баримтлан иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан ажиллаж байна.

2018 оны эхний 6 сард ЭХМК 20 удаа хуралдаж, 582 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг шийдвэрлэлээ.

- Үүнд: Хөдөлмөрийн чадвар алдалт тогтоосон
Анх тогтоосон-174

Сунгасан-372

Цуцалсан-31

- Шалгасан эмнэлэгийн хуудас
Хөдөлмөрийн чадвар алдалт-6041

Жирэмсэн амаржсан-2659

ҮОМШӨ-ний хөдөлмөрийн чадвар алдалт-42

ҮОМШӨ-ний сувилал-6 тус тус шалгалаа.

Архивын ажлын талаар:

1178 иргэний 1992-2016 онд төлсөн Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолтыг гаргаж үйлчиллээ.

Тэтгэврийн байцаагчдаас тэтгэвэр нь зогсоогдсон өндөр насны тэтгэвэр авагч 136, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 86, тахир дутуугийн тэтгэвэр авагч 65 буюу нийт 287 иргэний хувийн хэргийг бүртгэн авч, хадгаламжийн нэгж үүсгэн архивт шилжүүллээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн 23 албан бичигт дурдсан хүсэлтийн дагуу аж ахуйн нэгж байгууллага, иргэний нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг эсэх, тэтгэвэр, тэтгэмж авдаг эсэх талаарх лавлагааг цаг тухайд нь гарган хүргүүллээ.

Тус хэлтсийн 2017 оны баримтуудыг архивт хүлээн авах хуваарийн дагуу хадгаламжийн нэгжийн цахим бүртгэл хөтлөн мэдээллийн баазад оруулан бүртгэлжүүлж байна.

Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах тухай хуулиар 1990-2000 оны ажилласан жилээ нөхүүлэн нөхөн даатгалд хамрагдсан 46 иргэнд лавлагаа гаргаж үйлчилсэн

Бичиг хэрэг, дотоод хяналтын чиглэлээр:

Дээд шатны байгууллагууд болон аж ахуй нэгж байгууллагуудаас ирсэн нийт тушаал шийдвэр болон албан бичиг хүсэлтийг бүртгэн авч, хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлүүлэн ажиллалаа.

Иргэд даатгуулагчаас 2018 оны 2 дугаар улиралд нийт 262 өргөдөл ирүүлснээс 254 өргөдлийн хариуг хугацаанд нь шийдвэрлэн, 8 өргөдөл шийдвэрлэх шатандаа явагдаж байна

Үүнээс тэтгэмж –13, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх 33, тэтгэвэр тогтоох, нэмэгдүүлэх тухай 8, эрүүл мэндийн даатгалд давхар төлсөн шимтгэлээ буцаан авах 84, сайн дурын даатгал ажил олгогчтой давхар төлсөн шимтгэлээ буцаан авах тухай 100, групп сунгуулах тухай 8, бусад- 16 өргөдлүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллалаа.

Тайлант хугацаанд 980 албан бичиг явуулсны 43 нь хариутай бичиг байснаас хариуг нь хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлүүлээ. Ирсэн бичиг 812 ирсэнээс шийдвэрлэсэн нь 769 байна.

Хэлтсийн ажилнуудын ажлын цаг ашиглалтыг цаг ашиглалтын программаар бүртгэн ирцийн мэдээг сар бүрийн сүүлээр гарган хэлтсийн удирдлагад танилцуулан ажиллаж байна. тушаал шийдвэр болон албан бичиг хүсэлтийг бүртгэн авч, хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлүүлэн ажиллалаа.

Хүний нөөцийн чиглэлээр:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2011 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төрийн ёс зүйг дээдлэх, ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ”ний тухай журам мөн оны “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм”-ийн биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон ажил төрлийн холбогдолтой шинээр гарсан хууль тогтоомж, заавар журмыг ажилтнуудад цаг тухайд нь хүргэж, биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2011 оны 72 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний хэм хэмжээ” болон “Нийгмийн даатгалын ажилтны ажлын тусгай, хувцас, ялгах тэмдэг, тэдгээрийг хэрэглэх журам”-ын дагуу хэлтсийн албан хаагчдын дүрэмт хувцсыг албан үүрэг гүйцэтгэх явцдаа өдөр тутам өмссөн эсэхэд хяналт тавьж, биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн судалгааг шинэчлэсэн программд бүх албан хаагчдын судалгааг хугацаанд нь оруулж, хүргүүлсэн болно.

Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт өгч тэнцсэн Ж. Мөнхзаяагийн нэр дэвшүүлэх бичгийг Нийслэлийн төрийн албаны зөвлөлд хүргүүлэн нэр дэвшүүлэх бичгийг гаргуулан авсан. “Төрийн жинхэнэ албан хаагч”-ийн тангараг өргүүлэхээр материалыг бэлдэн дээд газарт хүргүүлэхэд бэлэн болсон.

Хэлтсийн 2018 оны нийт албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоон баталуулахаар төслөөр бэлдсэн.

2018 оны хэлтсийн ажилчдын ээлжийн амралтын хуваарийг тасгийн дарга нараас авч амрах хуваарийг гаргасан.

ХАСХОМ-ын тайлан нийт 33 байцаагчдаас хугацаанд нь цаасан болон цахим хэлбэрээр авч тайланг дээд байгууллагад хүргүүлсэн.

Мөн шинээр 3 төрийн захиргааны албан хаагчаар томилогдохоор нэр дэвшээд байсан албан хаагчдын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч Авлигатай тэмцэх газарт тухай бүрт нь хүргүүлэн, хариуг авч томилон ажиллуулж байна.

Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний тайланг улирал бүр үнэн зөв гарган холбогдох байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлэн мөн мэдээллийн баазад холбогдох мэдээллийг тухай бүрт үнэн зөв оруулан ажиллаж байна.

Байцаагчийн дэвтэр баталгаажуулах дардас,тамганы дутагдалгүй ажиллаж байна.

Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 76 жилийн ойг тохиолдуулан байцаагч ажилтнуудын шагналын тодорхойлолтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж тэтгэмжийн байцаагч Ч.Баярмаа Хөдөлмөр нийгмийн хамгааллын тэргүүний ажилтан, сайн дурын даатгал хариуцсан байцаагч Т.Гэрэлтунгалаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Жуух бичиг”, эрүүл мэндийн даатгалын орлого, шимтгэл хариуцсан байцаагч Г.Хэрлэнчимэг нийгмийн даатгалын ерөнхий газрын Хүндэт ажилтан” цол тэмдгээр тус тус шагнагдлаа.

Мөн ахмад ажилтан Б. Жаргалын материалыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Хүндэт ажилтан” цол тэмдгээр шагнуулах материалыг хүргүүлж, шагнууллаа.

Сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Хэлтсийн нийт байцаагч ажилтнуудыг чадавхжуулах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, нийгмийн даатгалтай холбогдолтой шинээр гарсан дүрэм, журам, заавруудыг танилцуулах, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг бүрдүүлэхэд анхаарах асуудал, Үр дүнгийн гэрээ байгуулахад анхаарах асуудал, Зөрчлийн тухай хууль түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, Харилцааны сэтгэл зүй, Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал, Архив албан хэрэг хөтлөлт, Эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудал, Ажлын байрны стандарт, Амьдралыг өөрчлөх, эмх цэгц ба түүний гайхамшигт ид, шид, "Эерэг сэтгэлгээ-хандлагаа өөрчлөх нь, 5S ажлын байрны эмх цэгц, Дохионы хэл, "Даатгалын зуучлал" зэрэг сэдвүүдээр 18 удаагийн сургалт зохион байгууллаа.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад дээд шатны байгууллагаас зохион байгуулсан сургалтанд нийт байцаагч ажилтнуудын 82 хувийг хамрууллаа.



Мөн хэлтэст томилогдон шинээр ажилд орсон байцаагч нарт Нийгмийн даатгалын тухай хуулиуд болон Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд дагаж мөрдөх журам, дүрмүүдтэй танилцуулах сургалт зохион байгууллаа



Улаанбаатар цахилгаан түгээх ТӨУҮГ-ын харьяа Зуслангийн цахилгаан түгээх сүлжээний ажилтан албан хаагчид, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лабораторын лаборант, мэргэжилтнүүд, 4,103,108-р цэцэрлэгийн багш ажилтан, Цагдаагийн ерөнхий газрын Тусгай ажиллагааны газрын алба хаагчид зэрэг нийт 20 гаруй ажил олгогчдийн 1905 даатгуулагчдыг хамруулан Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтүүд, нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлах сургалтуудыг зохион байгууллаа.



Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2018 оны А/32 тоот захирамжаар батлагдсан хуваарийн дагуу дүүргийн 1-19-р хороонд “Нээлттэй хаалганы өдөр-Нэг цонхны үйлчилгээ”-г хороодын Иргэний танхимд сар бүрийн 2-р 7 хоногийн 4 дэхь өдөр зохион байгуулан хэвшлээ.

“Нээлттэй хаалганы өдөр-Нэг цонхны үйлчилгээ”-нд иргэд, даатгуулагчид Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах удирдамжийн боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хороодын дарга нарт 7 хоногийн өмнө зар хүргүүлж бэлтгэл ажлыг ханган зохион байгууллаа.

“Нээлттэй өдөрлөг-Нэг цонхны үйлчилгээ” өдөрлөгөөр 1-19-р хорооны 469 иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, холбогдох хууль тогтоомжоор нэг бүрчлэн зөвлөгөө мэдээлэл өглөө



Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, ярилцлага хэлэлцүүлэг, Нээлттэй өдөрлөгийг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Ахмадын хороо болон бусад хэлтсүүдтэй хамтран зохион байгуулж 4172 иргэн даатгуулагчид зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Үүнд:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр сурталчлах, иргэдэд нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа таниулах, нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлыг сурталчлах, иргэдийг сайн дурын даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамруулах иргэд, даатгуулагчдын санал хүсэлтийг сонсох "НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ" Бөмбөгөр худалдааны төв, Хүчит шонхор худалдааны төв, Нарантуул-2 худалдааны төвүүдэд, зохион байгууллаа.

Нээлттэй өдөрлөгөөр зохион байгуулагдаж буй үйл ажиллагааны талаар хэлтсийн дарга Ш.Алтанчимэг, сайн дурын даатгал хариуцсан байцаагч Д.Дэлгэрцэцэг нар MNC телевизэд ярилцлага өгч, 2018 оны 04-р сарын 21-ны оройн 19.00, 21.00 цагуудад мэдээний цагаар телевизээр мэдээлэл болон зохион байгуулагдсан үйл ажиллагааны талаар мэдээ цацагдлаа.

Тус өдөрлөгийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 1000 иргэд даатгуулагчид оролцож, нийгмийн даатгалын үйлчилгээг нэг дороос цогц үйлчилгээ үзүүлээ



УИХ-ын гишүүн МУ-ын Шадар сайд Ө.Энхтүвшин тойргийнхоо 12,13,14,15-р хорооны иргэдтэй хийж байгаа уулзалтанд хэлтсийн дарга Ш.Алтанчимэг, тэтгэврийн байцаагч Б.Ариунцэцэг, Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого хариуцсан байцаагч Г.Хэрлэнчимэг, сургалт сурталчилгааны мэргэжилтэн

Б.Нарантуяа нар оролцож иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын холбогдолтой мэдээлэл өгч, иргэдийн сонирхсон асуултанд хариуллаа.

УИХ-ын гишүүн, Өргөдлийн байнгийн хорооны дарга М.Оюунчимэгийн 8,9,10-р хорооны иргэдтэй уулзах уулзалтанд оролцож иргэдийн сонирхсон Нийгмийн холбогдолтой асуултанд хариулт өглөө.



Ахмад настны нийгмийн хамгаалал сургалт, хэлэлцүүлэгт 1-19-р хороодоос оролцсон 1300 гаруй ахмад настанд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтүүд, тэтгэвэр нэмэгдүүлэхтэй холбогдож гарсан МУЗГ-ын тогтоолуудын хэрэгжилт сэдвээр мэдээлэл хийлээ.



Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч Эрдэнэтуяагийн 13,14,15-р хорооны иргэдтэй уулзах уулзалтанд оролцож нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өглөө.

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн санаачлагаар Нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Татварын хэлтсүүд хамтран "Ажил олгогчдын уулзалт сургалт" зохион сургалтанд хамрагдсан 150 гаруй ААН, байгууллагын дарга, нягтлан бодогч нар Нийгмийн даатгалын тухай хуулиудад

орсон нэмэлт өөрчлөлтүүд сэдвээр тэтгэврийн байцаагч Б.Ариунцэцэг илтгэл тавьж оролцогсодын сонирхсон асуултанд хариулт өглөө.




Сэтгэл ханамжийн судалгааг 1 удаа 500 гаруй даатгуулагч, иргэдээс авч нэгтгэн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гарган ажиллаж байна.

Судалгаанд давхардсан тоогоор

- сайн дурын даатгалд хамрагддаг 115
 - эрүүл мэндийн даатгалд хамрагддаг 186 даатгуулагч
- Судалгаанд хамрагдсан иргэдийн 48,7 хувь нь сайн дурын даатгалд, 78,8 хувь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байлаа.

- Өндөр насны тэтгэвэр авагч - 55
- Тахир дутуугийн тэтгэвэр авагч -10
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч -15
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авагч-19
- Жирэмсэн амаржсаны тэтгэмж авагч-41
- Оршуулгын тэтгэмж авагч-16
- Ажилгүйдлийн тэтгэмж авагч-22 даатгуулагчдыг хамрууллаа.


II. Танд үйлчилгээ үзүүлсэн нийгмийн даатгалын ажилтны ёс зүй зан харьцааг хэрхэн үнэлж байна вэ?



III. Та манай байгууллагаар үйлчлүүлснээр өөрт тулгарсан асуудлаа шийдвэрлүүлж чадсан уу?


- 68 хувь нь өөрт тулгарсан асуудлаа бүрэн шийдвэрлүүлсэн
- 26 хувь нь ихэнхийг нь шийдвэрлүүлсэн

- 5 хувь нь бараг шийдвэрлээгүй
- 1 хувь нь юу ч шийдвэрлүүлж чадаагүй



IV. Нийгмийн даатгалын холбогдолтой мэдээллийг та хаанаас авдаг вэ?

- Нийгмийн даатгалтай холбогдолтой мэдээллийг 37,2 хувь нь нийгмийн даатгалын байгууллагаас авдаг
- 47,8 хувь нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр авдаг
- 13,5 хувь нь нийгмийн даатгалын холбогдолтой тараах материалаас авдаг гэж хариулсан байна



Хэлтсийнхээ гадна орчныг 50 м доторх цэвэрлэгээг 4 удаа хийлээ.



ТАНИЛЦСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА Ш.АЛТАНЧИМЭГ

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАСГИЙН ДАРГА Н.АЛТАНТУЯА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ
МЭРГЭЖИЛТЭН Б.НАРАНТУЯА